

НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨАТҮГ-ЫН АВЛИГЫН ЭСРЭГ
 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2021 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр

Налайх дүүрэг


Д/д	Үйл ажиллагаа	Хэрэгжилт	Биелэлт
1	Байгууллагын хэмжээнд мөрдөгдөж байгаа дүрэм, журам болон гэрээнүүдэд нэмэлт өөрчлөлт оруулах	Байгууллагад мөрдөгдөж буй Ёс зүйн дүрэм болон Нууцын журам, нууцын баталгааны хуудсыг шинээр боловсруулж батлуулсан.	100
2	Шилэн дансны тухай хууль хэрэгжүүлж холбогдох мэдээллийг тогтмол мэдээлэлж байх	Авилгын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2; Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5; Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, холбогдох мэдээллийг тогтмол мэдээлэн ажиллаж байна.	100
3	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу хөрөнгө орлогын мэдүүлэг өгөх	Авилгын эсрэг хуулийн 10 дугаар зүйлд "10.3.Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ тухайн албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн алба хааж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан байгууллага, албан тушаалтанд өгөх үүрэгтэй" заасны дагуу байгууллагын дарга, ахлах нягтлан бодогч нар хуулийн хугацаанд мэдүүлсэн болно.	100
4	Байгууллагын дотоод сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангаж ажилчдад мэдээллийг ил тод, шуурхай хүргэж ажиллах	Дотоод сүлжээний системийг иж бүрнээр нь бүх албан хаагчид ашиглаж байна.	100
5	Авилгатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг нь хугацаанд мэдэгдэх	Авилгатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, Зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээ,	

6	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, ил тод байдлыг хангах	АТГ-аас бэлтгэсэн тв, шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном гарын авлага зэргийг өөрийн байгууллагын албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер) суртчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэж ажилласан.	100
7	Удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэр /тушаал, тогтоол/-ийг цахим хуудсанд байшуулах	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж /хуульчилсан акт/ дүрэм, журам, зааврыг байгууллагын цахим хуудсанд тухай бүр нь байршуулан ажилласан.	100
8	Авлигын эсрэг хуулийн сургалт зохион байгуулах, албан хаагчдыг хамруулах	Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлд заасан чиг үүрэг бүрэн эрхийн хүрээнд Авлигатай тэмцэх газраас төрийн байгууллагын албан хаагч нарт авлигын талаарх мэдлэгийн дээшлүүлэх, авлигаас нийгэмд учруулах хор аюулыг ухуулан сурталчлах хүрээнд НЗДТГ-аас зохион байгуулсан цахим сургалтад байгууллагын албан хаагчид хамрагдсан.	100
9	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах	100

ХЯНАСАН:

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

2022 оны 01 дүгээр сарын 14- ны өдөр



Н.ПҮРЭВСҮРЭН

БОЛОВСРУУЛСАН:

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН



Б.АРИУНБИЛЭГ